

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

3. Эрдэнэчимэг

**АФРИКИЙН АРД ТҮМНИЙ ШУДРАГА ТЭМЦЭЛ,
БНМАУ-ЫН БОДЛОГО**

Африкийн ард түмэн улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө, харийн колоничлолыг эсэргүүцсэн урт удаан хугацааны тэмцэл өрнүүлж ирсэн бөгөөд тэдний тэмцэлд аугаа Октябрийн социалист их хувьсгал хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

Ялангуяа дэлхийн социалист систем бүрэлдэн тогтсон явдал нь энх тайвныг эрхэмлэгч бүх хүчин, түүний дотор Африкийн дэвшилт ардчилсан хүчнээс тусгаар тогтнолоо бэхжүүлэх, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж байгаа юм. Үүнээс үзвэл «Социалист систем, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний холбоог бэхжүүлэх нь империализмын эсрэг тэмцлийн хэтийн төлөвт тэргүүн зэргийн ач холбогдолтой»¹ гэж коммунист, ажилчны намуудын олон улсын зөвлөлгөөнөөс гарсан зарчмын дүгнэлт орчин үед амьдралд улам бүр тусгалаа олж байгаа нь илт байна. Бүх улс түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, цаашдын хөгжил дэвшил болон энх тайвны аюулгүй байдлын төлөө тэмцэж байгаа эрин үеийн хувьсгалт хүч нь дэлхийн социалист систем, капиталист орнууд дахь коммунист намуудаар манлайлуулсан ажилчин ангийн хөдөлгөөн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн энэ гурван хүчнээс бүрдэж байна.

50-иад оны сүүлчээр Африкийн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн урьд өмнө үзэгдээгүй их хэмжээтэй өрнөж Гвиней, Гана, Ливи, Судан зэрэг хэд хэдэн улс тусгаар тогтнолоо тунхаглаж, африкийн ард түмэн олон улсын амьдралд идэвхтэй оролцох болсон юм. Ийнхүү африкийн ард түмний шудрага тэмцлийн үр дүнд тусгаар тогтносон улс орон шинээр төрөн гарсаар байна. Одоо хоцрогдмол хэвээр байгаа боловч колони хараат орнуудын хөдөлмөрчин, тариачин олон дэлхий дахины хувьсгалын дараа дараагийн шатанд маш том үүрэг гүйцэтгэнэ»² гэж В. И. Лениний угтан хэлсэн нь амьдралд бүрэн нотлогдож байна. Зөвхөн 1960 онд Африк тивд шинээр тусгаар тогтнолоо зарласан 11 улс төрөн гарчээ. 70-аад оны дундуур Португалийн сүүлчийн колони байсан Гвиней-Бисау, Ногоон хошууны арал, Ангол, Мозамбик, Сан Томен Принципийн Арлуудын ард түмэн түүхэн ялалт олсон нь онцгой ач холбогдолтой болжээ. Энэ нь империализм, колоничлол, шинэ колоничлолын болон арьсны үзлийн эсрэг Африкийн улс түмний тэмцэлд үндсэн эргэлт болсон их хүчин зүйл болжээ. 30 гаруй сая хавтгай дөрвөлжин км нутаг, 400 сая гаруй хүн амтай Африк тивийн 51 орон колонийн дарлалд нухлагдаж байснаас одоо 49 орон тусгаар тогтнолоо нэгэнт тунхагласан ажээ.

Ер нь улс төрийн тусгаар тогтнолоо байлдан олсон орнуудын өмнө цаашид хөгжлийн ямар замыг сонгон авах тухай асуудал юуны өмнө тул-

1 Олон улсын коммунист, ажилчны намуудын зөвлөлгөөний баримт бичиг, УБ., 1969 он, 35-р тал

2 В. И. Ленин. Зохиолуудын 32-р боть, 494-р тал.

гарч ирдэг байна. Ийм ч учраас энэ асуудлыг ЗСБНХУ-ын дорно дахины бүгд найрамдах улсууд болон БНМАУ-д шийдвэрлэсэн байдал, тухайлбал тэдгээрийн капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлагыг саяхан колонийн дарлалаас чөлөөлөгдөн тусгаар тогтнолоо олсон Африкийн орнууд зүй ёсоор сонирхож байна.

МАХН-ын программд заахдаа: «БНМАУ-ын туршлага нь хөгжлийн хувьд хоцрогдсон орон хөгжлийн капиталист шатыг алгасан социализмд дэвшин орж болох тухай марксист-ленинист сургаалын үнэн зөвийг хэрэг дээр яруу тод харууллаа. Колоничлолын дарлалыг таягдан хаясан ард түмэн ганцхан энэ замаар явж олон үеийн хоцрогдол, ядуу зүдүү байдлаа хамгийн хурдан бөгөөд зовлон гамшиггүй даван туулж, ардчилал социализмын замд дэвшин орж сая чадна»³ гэжээ. БНМАУ капиталист биш хөгжлийн замаар замнан социализмыг амжилттай байгуулсан нь хэдийгээр өвөрмөц шинж чанартай боловч энэ нь аль ч оронд социализм байгуулах түгээмэл зүй тогтлын дагуу явагдсан байна. Тэгэхдээ улс түмэн үндэсний болон нийгмийнхээ эрх чөлөөг олох зорилтыг гагцхүү олон улсын ажилчны хөдөлгөөнтэй нягт холбоотой, эв санааны нэгдэлтэй явж байж л сая амжилттай шийдвэрлэж чадна гэдгийг БНМАУ-ын туршлага нотолсон юм. Орчин үед Ази, Африк, Латин Америкийн шинээр тусгаар тогтносон улсууд Зөвлөлтийн дорно дахины бүгд найрамдах улсууд болон БНМАУ-ын амьдралд нэгэнт шалгагдсан капиталист биш хөгжлийн туршлагыг хэрэглэх хандлага их гарч ирж байгаа ба тэдгээр орнуудын ард түмэн социализмын давуу талыг ухааран ойлгож байгаагийн бас нэг нотолгоо мөн гэж үзүүштэй.

Сүүлийн 10 гаруй жилийн дотор арваад улс хөгжлийн социалист чиг баримжааг сонгон авсны ихэнх нь Африк тивт оршиж байна. Тухайлбал, Алжир, Гвиней, Танзани, Ангол, Мозамбик. Гвиней-Бисау Конго, Нигери, Мадагаскар, Бенин зэрэг орнууд капиталист биш хөгжлийн зам, социалист чиг баримжааг сонгон авч нийгэм-эдийн засгийн дэвшилт өөрчлөлтүүд хийж байна. Эдгээр орнуудын хувьсгалт ардчилсан намууд улс орноо хөгжүүлэх үйл ажиллагаандаа шинжлэх ухааны социализмын зарчмыг үндэс болгон, улс төрийн тусгаар тогтнолоо бэхжүүлж, эдийн засгийн биеэ даасан байдлыг хангах, социалист нийгэмд шилжих материаллаг бааз байгуулах явдлыг гол зорилтоо болгож байна. Африкийн шинэ тулгар улсууд, биеэ даасан эдийн засгийн төлөө тэмцэлдээ их амжилт олж байгаа бөгөөд гадаадын капиталыг шахан зайлуулах, улсын сектор байгуулах зэрэг дэвшилт өөрчлөлтүүдийг хийсээр байна. Тус тивийн хөгжиж байгаа орнууд олон улсын эдийн засгийн эрх тэгш харилцаа тогтоохын төлөө урьд хожид үзэгдээгүй их цар хүрээтэй тэмцэл явуулж байна.

Эдийн засгийн тэгш биш байдал, ялгаварлан гадуурхах явдал, санхүүгийн мөлжлөг, монополийн ноёрхлын системийг эцэс болгох гэсэн тэдний эрмэлзлэлийг социалист хамтын нөхөрлөлийн орнууд бүр эхнээс нь тууштай дэмжиж ирсэн юм.

ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орнууд шинэ тулгар улс орнуудтай тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр бүх талын харилцаа холбоогоо өргөжүүлэн хөгжүүлж, тэдгээр орнуудын нийгэм, эдийн засгийн биеэ даасан байдал, тусгаар тогтнолоо бэхжүүлэхэд нь байнга дэмжлэг үзүүлдэг юм. ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас Африкийн чөлөөлөгдсөн орнуудтай тогтоосон эрх тэгш шударга эдийн засгийн харилцаа нь эдгээр орнуудын улс төр, эдийн

3 МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 3 дугаар дэвтэр, (1961-1970) УБ., 1970. 262-р тал.

засгийн хөгжилд идэвхтэй нөлөөлж, империалистуудаас шахалт үзүүлэх явдлыг нь багасгаж байна. ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд Африкийн шинэ тулгар хөгжиж байгаа 34 оронтой гэрээ хэлэлцээр хийж, эдийн засгийн биеэ даасан байдлын үндэс болох аж үйлдвэрийг хөгжүүлэх, удаан хугацааны зээл олгох, үндэсний боловсон хүчин бэлтгэхэд нь тусалж байна. Социалист улсуудаас Африкийн хөгжиж байгаа орнуудад гаргаж байгаа бараа товарын 60-75 хувийг тэдгээр орны үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардагдах машин, тоног төхөөрөмж эзэлж байна. Иймээс хөгжиж буй орнууд хөвөн, арьс шир, кофе, какао зэрэг түүхий эд, үйлдвэрийн бүтээгдэхүүнээ борлуулах тогтвортой зах зээлтэй болжээ. ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд Африкийн улсуудаас ээрсэн утас, бөс бараа зэрэг зарим төрлийн хэрэгцээний бараа товар худалдан авч байна. Африкийн нилээд улсад ЗХУ, социалист бусад орны тусламжтайгаар үйлдвэрлэлийн шинэ шинэ салбарууд байгуулагдаж байгаагийн дотор хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэр, эрчим хүч, машины үйлдвэр, химийн ба нэхмэлийн үйлдвэрүүд гол суурийг эзэлж байна. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас Африкийн тэдгээр улсад үзүүлж байгаа тусламж нь империализм, шинэ колоничлолын эсрэг улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар тогтнол олохын төлөө тэмцэж байгаа Африкийн нийт ард түмний тэмцэлд оруулж байгаа хувь нэмэр даруй мөн.

Африкийн нилээд улс орон хөгжлийн социалист чиг баримжааг сонгон авч, социалист орнуудтай улс төр, эдийн засгийн харилцаагаа тийнхүү улам өргөжүүлэн хөгжүүлж, тус тивд империализмын нөлөө улам бүр хумигдаж байна. Чухам ийм нөхцөлд АНУ болон империалист бусад гүрнүүд Африк тивд өөрийн ноёрхлыг алдахгүйн тулд юуны өмнө ӨАБНУ, Родези, Намибийг хамарсан Өмнөд Африк дахь түшиц цайзыг хэвээр байлгахын төлөө гол чармайлтаа гаргаж байна. Империалист гүрнүүд африкийн шинэ тулгар орнуудыг хөгжил дэвшлийн замаас нь түлхэн гаргах, биеэ даасан эдийн засгийг байгуулахад нь саад болж, эдийн засагт нь хуучин байр сууриа бататгаад зогсохгүй, улмаар тэдгээр орнуудыг нийгэм-эдийн засгийн болон цэрэг стратегийн талаар хяналтандаа оруулах шинэ колоничлолын бодлого явуулж байна. «Ю. С. Ньюс энд Уорлд рипорт» сэтгүүлд нийтлэгдсэн ярилцлагандаа Америкийн гадаад бодлогод Африк ямар байр суурь эзлэж байна вэ? гэсэн асуултанд АНУ-ын ерөнхийлөгч Ж. Картер хариулахдаа «10, 15, 20 жилийн удаан хугацаатай манай стратегийн хэрэгцээ энэ тивийн улсуудтай харилцан итгэж, зузаан найрамдал, нийгэм улс төрийн нягт холбоо тогтоохыг шаардаж байна»⁴ гэж хариулжээ. Үүнээс үзэхэд Вашингтоны зүгээс Африкийн орнуудад, нийгэм, улс төрийн холбоо», «зузаан найрамдал» гэгч шинэ колоничлолын бодлогыг шууд тулган хүлээлгэх гэсэн нь хэн бүхэнд илэрхий байна. АНУ-аас Африкийн орнуудтай «зузаан найрамдал» тогтоох гэсэн оролдлогын жинхэнэ зорилго нь тус тивд цэргийн эвсэл байгуулах, Африкийн улсуудыг өөр хоорондоо тэмцэлдсэн бүлэглэлд хувааж хүчийн нь сулруулж, тэдний дотоод хэрэгт хөндлөнгөөс шууд оролцох явдлаа улам өргөжүүлэх явдал юм. АНУ-аар толгойлуулсан НАТО-гийн орнууд Зайрын хэрэгт хөндлөнгөөс оролцож тус улсын нутаг дэвсгэрийг хөрш зэргэлдээ дэвшилт улсуудын эсрэг түрэмгийлэл үйлдэх түшиц газар болгон ашиглахыг эрмэлзэж байна. Сомали, Этиопийн хооронд гарсан маргааныг империалист хүчнүүд овжин ашиглаж, уг хэрэг явдлыг ноцтой тийш нь дэвэргэн түлхэж байна. АНУ цэрэг, аж үйлдвэрийн цогцолбор болсон Өмнөд Африкийг эдийн засгийн нь хувьд ихээхэн сонирхож байгаа юм.

АНУ тэндээс ванадийн 57, цагаан алтны 48, хромын 30 хувийг авч байгаа ажээ. ӨАБНУ, Намибид гэхэд Америкийн хөрөнгө оруулалт 1976 оны сүүлчээр 2 тэрбум доллараас давжээ. АНУ болон өрнөдийн гүрнүүд Африк тивийн өмнөд хэсэгт хүний хүч, байгалийн асар их нөөцийг хайр гамгүй мөлжих явдлаа эрчимжүүлж байна.

Орчин үед олон улсын үйл хэрэгт Африкийн орнуудын роль улам бүр өсөн нэмэгдэж байгааг Бээжингийн эрх баригчид ашиглаж, Африкийн улс түмний дунд өөрийн нөлөөг бататгахын төлөө улайран тэмцэж, улмаар Африкийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд удирдах байр суурь олж авах, өөрийн жанжлах зорилгодоо захируулахыг эрмэлзсэн улс төрийн явууллагаа улам бүр идэвхжүүлж байна. Бээжингийнхний «Африкт явуулах төлөвлөгөө» гэгч нь социализмын эсрэг, ялангуяа ЗХУ-ын эсрэг гүжир гүтгэлгийг Африкийн улс түмний дунд дэлгэрүүлэх зорилгыг агуулж байна. Бээжин 60-аад оны дундуур Африк дахь хятадын бодлогын «онцгой» таван зарчмыг тунхаглаж, империализмын эсрэг тэмцэл, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, Африкийн улс түмний нэгдэх эрмэлзлэл, улс дундын маргааныг тайван замаар шийдвэрлэх хүчин чармайлтыг дэмжинэ гэж зарласан хэдий боловч хэрэг дээрээ тэдний ам ажил хоёр сүрхий зөрж байгаа юм.

Дэлхийн бүх харгис хүчнийг нэгтгэх нь Хятадын одоогийн маоист эрх баригчдын гадаад улс төрийн бодлогын гол зорилго болж байна.

Анголын нутаг дахь тулалдааны явцад африкчууд олон улсын тайзан дээр хэн өөрсдийн нь жинхэнэ нөхөр, хэн заналт дайсан гэдгийг тод харсан билээ. ЗХУ, Куба болон бусад социалист улсын зүгээс Анголын баатарлаг ард түмэнтэй эв санаагаа нэгтгэн, тэдний тусгаар тогтнол, эрх чөлөөг империалистууд арьсны үзэлтнүүдийн аюул заналаас хамгаалахад нь шууд тусалсан билээ. Гэтэл маогийнхан империалист гүрнүүдтэй эвсэж ЗХУ, Кубын ард түмнээс үзүүлсэн интернационалч тусламжийг ичгүүр сонжуургүй гүтгэн гуйвуулж, дайран давшилсаар байгаа билээ. Бүр 60-аад оны үеэс хятадын эрх баригчид Анголын ард түмний хувьсгалт тэмцлийн манлай МПЛА (Анголыг чөлөөлөх Ардын Хөдөлгөөн) намын эсрэг хорлон сүйтгэх дайсагнасан байр суурийг баримтлан, империалистууд болон арьсны үзэлтнүүдтэй сүлбэлдэн ФНЛА, УНИТА-ийн толгойлогчдыг «Ивээгчийн» үүрэг гүйтэтгэж байв.

Маогийнхан Африкийн орнуудын зарим удирдагчдын үндсэрхэг үзлийг ашиглаж «гурав дахь ертөнцийг» арьс өнгөний үзлийн үндсэн дээр нэгтгэн нягтруулахыг уриалж байна. Бээжингийнхэн «гурав дахь ертөнц», «цагаан арьстны ертөнцийн» хооронд арьсны өнгөөр ялгаварлах дайн зайлшгүй гарна гэж цуурхаад, тэрхүү бузар үзэл санаандаа Африкийн улс түмнийг татан оруулахыг хичээж байна.

Чухам ингэснээрээ Бээжингийн эрх баригчид социализм, олон улсын ажилчин ангийн эрх ашгаас бүрмөсөн урваад зогсоогүй үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эрх ашгаас урван тэрслэж империалист харгис хүчин, арьсны үзэлтнүүдтэй шууд нэгдмэл фронт байгуулж байна.

Гэвч орчин үед шинэ колонилол, арьсны үзэлт дэглэм, маоизм харгислалын нэгдсэн хүчний эсрэг Африкийн өмнөд хэсгийн улс түмний тэмцэл улам өргөжин бэхжсээр байна. Энэ тэмцэл империализмын эсрэг энх тайван, шудрага ёс, үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж буй дэлхийн өнцөг булан бүрийн улс түмний тэмцэлтэй салшгүй холбоо той юм. БНМАУ, түүний засгийн газар империализм, шинэ колонилолын эсрэг Ази, Африк, Латин Америкийн ард түмнээс явуулж буй үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй ямагт хамт явж ирсэн, явсаар ч байна. Монгол улс Африкийн шинэ тулгар улсуудтай энх тайвнаар зэрэг-

цэн орших, харилцан хүндэтгэх тэгш эрхийн зарчмын үндсэн дээр найрамдалт харилцаа тогтоож, түүнийг цаашид бэхжүүлэх талаар чармайлт тавьж, дэлхий дахинд энх тайван, улс түмний аюулгүй байдлыг ханган бэхжүүлэхийн төлөв бүх дэвшилт хүчинтэй хамтын тэмцэл явуулахад гадаад бодлогоо чиглүүлж байна.

МАХН өөрийн үйл ажиллагаандаа марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын үзэл санааг цаг ямагт удирдлага болгож ирсэн юм. Манай намын программын баримт бичгүүдэд дэлхий дахины хөдөлмөрчид хийгээд дэлхийн эзэрхэг түрэмгийтэнд дарлагдан боолчлогдсон улс түмэн эрх ашиг, эв санаа нэгтэй байж эв нэгдэлтэй ажиллахыг орон бүхний хувьсгалч нарт уриалж байсан»⁵ тухай дурдаж бичсэн байдаг. МАХН ын их хурлуудын баримт бичгүүдэд колони, хараат орнуудын ард түмний империализм колонийн дарлалыг эсэргүүцсэн шудрага тэмцлийг талархаж, эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэж байгаа бүх улс түмнийг дэмжсэн зүйл удаа дараа тусгагдаж байсан байна.

1955 онд хуралдсан Ази, Африкийн 29 орны олон сая хүн амыг төлөөлсөн Бандунгийн бага хурлын үзэл санаа, тус бага хурлаас гаргасан арван зарчмыг БНМАУ-ын Засгийн газар, Монголын ард түмэн талархан дэмжсэн юм.

1957 ны хоёрдугаар сард Ази, Африкийн орнуудтай эв санаагаа нэгтгэх Монголын хороо байгуулагдсан бөгөөд Монголын төлөөлөгчид Каирт болсон Ази, Африкийн ард түмний эв санааны нэгдлийн анхдугаар бага хуралд идэвхтэй оролцож, Ази, Африкийн ард түмний эв санааны нэгдлийн байгууллагыг үндэслэн байгуулсан орнуудын нэг юм.

БНМАУ нь НҮБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохдоо юуны өмнө колоничлол, шинэ колоничлолын бүхий л хэлбэрийг устгах, колоний ба хараат орны ард түмэнд тусгаар тогтнол олгох тухай тунхагийн заалтуудыг хэрэгжүүлэхийн төлөө шаргуу тэмцэж ирлээ.

1972 оны наймдугаар сард Улаанбаатар хотноо Ази, Африкийн эмэгтэйчүүдийн 2 дугаар бага хурал хуралдсан бөгөөд тус бага хуралд Ангол, Мозамбик, Алжир, Конго, Танзани зэрэг Африкийн хорь гаруй орны төлөөлөгчид оролцсон байна. Тус бага хурлаас гаргасан шийдвэрүүд нь Ази, Африкийн эмэгтэйчүүдээс улс орныхоо нийгмийн амьдралд идэвхтэй оролцох тэгш эрхий төлөө явуулж буй тэмцэлд чухал ач холбогдолтой болжээ.

БНМАУ Африкийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих Африкийн орнуудын тусгаар тогтнол, улс төр, эдийн засгийн биеэ даасан байдлыг хангах, колоничлол, шинэ колоничлол, арьсны үзлийг бүрмөсөн устгах зорилго бүхий олон улсын уулзалт, хурал зөвлөлгөөнүүдэд, идэвхтэй оролцож, түүнээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцэж ирлээ.

Колоничлол, арьсны үзлийн сүүлчийн түшиц газар-Өмнөд Африк, Зимбабве, Намибийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн идэвхтэй өрнөж, ӨАБНУ-ын апартеидын дэглэмийн сүйрэн унах цаг улам ойрхож байна. Одоо ертөнц дахинд өрнөж байгаа намжмал байдлын үйл явц нь Өмнөд Африкийн дарлагдсан ард түмний шудрага үйл хэрэг ялахад таатай нөхцөл бүрдүүлж байна. Гэсэн ч Өмнөд Африкийн арьсны үзэлтнүүд апартейд бодлогыг төрийн бодлогын хэмжээнд хүргэж, улс түмний, энх тайван, эрх чөлөө, хөгжил дэвшлийн үйл хэрэгт харш явуулла-

гаа үргэлжлүүлсээр байна, Форстерийн дэглэм хүнийг үй олноор баривчлан тамлаж, алан хядах ажил явууллагаа улам хүчтэй болгож байна. 1976 оны зургадугаар сарын 16-нд Соуэтод болсон цуст явдлаас хойшхи хугацаанд ч олон зуун хүний амь үрэгдэв. Өмнөд Африкийн арьсны үзэлтнүүд зэвсэгт хүчин, цэрэг аж үйлдвэрийн хүч нөөцөө улам нэмэгдүүлж, уугуул ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарахад бэлтгэж байна. Иймд апартейдын асуудлаар гаргасан НҮБ-ын шийдвэрүүд, ялангуяа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXI чуулганаас баталсан апартейдын эсрэг тэмцэх үйл ажиллагааны программыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх явдал онц чухал ач холбогдолтой юм.

Өөрийн интернационалч үүрэгтээ ямагт үнэнч монголын ард түмэн, түүний засгийн газар арьсны үзэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлын эсрэг олон улсын тавцан дээр тууштай тэмцэж байдаг юм. Энэ талаар ч МАХН-ын программд: «Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, улс үндэстнийг дарлах, колоничлон дээрэмдэх, эдийн засгийн талаар мөлжих зэргээр олон улсын империализмын хэрэглэж байгаа бүх хэлбэртэй эвлэршгүй тэмцэж, колоничлолын бүхий л хэлбэр, илэрлийг нэн даруй бүрмөсөн устгахын төлөө шийдвэртэй тэмцлийг МАХН өөрийн шууд үүрэг гэж үзэж байна»⁶ гэж тэмдэглэсэн байдаг. БНМАУ арьсны өнгөөр гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцид эн тэргүүн нэгдэн орж, түүнийг бүрэн дүүрэн дэмжсээр байгаа юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XXXI чуулган дээр БНМАУ-ын Гадаад Явдлын Яамны сайд н. М. Дүгэрсүрэн хэлсэн үгэндээ: «БНМАУ дарлагдсан ард түмэн, эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө өөртөө байгаа бүх арга хэрэгслийг ашиглан тэмцэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх явдлыг үндэс болгодог юм. Африк дахь колоничлол, арьсны үзэлт дэглэмийн ноёрхлыг бүрмөсөн устгах талаар үр дүнтэй арга хэмжээ авах тухай шаардлагыг манай төлөөлөгчид дэмжиж байна»⁷ гэж тэмдэглэжээ.

Родезийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхагч хууль бус дэглэмээс Бүгд Найрамдах Мозамбик Ард Улсын эсрэг үйлдсэн шинэ түрэмгийлэл нь арьсны үзэлт шинэ колоничлолын хүчний бодлого улам бүр балмад болж байгааг харуулж байна. Арьсны үзэлтнүүдийн энэ балмад үйл ажиллагааг Монголын ард түмэн дэлхийн дэвшилт хүчний хамт шийдвэртэй буруушааж, империалист гүрнүүдээс Мозамбик болон Африкийн бусад орны эсрэг түрэмгий явууллагаа нэн даруй зогсоож, тэдгээр орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцохыг хатуу шаардсан мэдэгдэл гаргасан юм.

БНМАУ нийгмийн янз бүрийн байгуулал бүхий улс түмэн энх тайвнаар зэргэцэн орших явдлыг хангах, улсуудын дотоод хэрэгт үл оролцох зарчмыг хүндэтгэгч бүх оронтой хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зарчмыг удирдлага болгон тэдгээр орнуудын тусгаар тогтнол, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч тэдэнтэй найрамдалт харилцаа тогтоон хамтран ажиллаж байна. Энэ нь БНМАУ Африкийн шинэ тулгар орнуудтай улс төр, соёлын харилцааг хөгжүүлэхэд чухал үе шат боллоо. Манай улс нь Африкийн тусгаар тогтносон улсуудыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, тэдгээрийн 23-тай (1977 оны байдлаар) дипломат харилцаа тогтоогоод байна. Тухайлбал, Гвиней (1960. IV. 21), Мали 1961.1.25), Алжир. (1961. VII. 8), Египет (1968. IV. 2), Гана (1965. XII. 7), Конго (1966. XII 31) Танзани (1967. 1. 17), Этиопи (1967. 1. 24), Мавритани (1967. VI. 30), ТАБНУ (1970. VI. 18), Судан (1970. VII. 7), Мароккогийн Вант улс (1970. VII. 14), Сомали (1971. II. 28), Нигери (1971. IX, 21), Заир

6 МАХН-ын программ. УБ., 1966 он. 37-38 дахь тал

7 “Үнэн”. 1976. X. 6.

(1975. XI. 14), Мозамбик (1975. XI. 27), Гвиней-Бисау (1975. X. 14), Сан Томе ба Принсипи (1975. X. 22), Ногоон Хушууны Арал (1975. XI. 19), Ангол (1976. II. 10), Либерии (1976. IV. 23), Тунис (1977. II. 5), Бенин (1917. IV. 2) зэрэг орнуудтай тусгаар тогтнолын бүрэн эрхт байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг хүндэтгэх үндсэн дээр найрамдал, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн Элчин сайдын хэмжээнд дипломат харилцаа тогтоогоод байна. БНМАУ-аас Африкийн хөгжиж байгаа улсуудтай тогтоосон найрамдалт харилцаа нь төр, засгийн газрын тэргүүн, парламентын төлөөлөгчид харилцан айлчлах, олон улсын байгууллагуудад хамтран ажиллах зэрэг хэлбэрээр улам бүр хөгжиж байна. МАХН-ын удаа дараагийн их хурлуудад Африкийн олон орноос төлөөлөгчид оролцож, манай орны капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлагыг ихэд үнэлж, монголын ард түмний социалист бүтээн байгуулалтдаа олж байгаа амжилттай танилцаж байна. Тухайлбал, МАХН-ын XVI их хуралд оролцсон Конгын Хөдөлмөрийн намын төлөөлөгч Жан Пьер Ноно тус их хурал дээр хэлсэн үгэндээ: «Монгол улс, дэлхийд анх түрүүн капиталист шатыг алгасан социализмд шууд шилжиж орсон учраас МАХН-ын мэргэн удирдлагаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүтээж байгаа үйлсийг манай оронд халуунаар талархан сонирхож байна. Иймд Конгын ард түмэн, түүний нам феодалын нийгмээс социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрэн ялах хүртэл урт удаан замыг маш ахар богино хугацаанд туулсан монголын хувьсгалыг өндөр үнэлж байна⁸ гэжээ.

1960 оны есдүгээр сард БНМАУ-ын Засгийн газрын урилгаар Бүгд Найрамдах Гвиней улсын Ерөнхий сайд Секу Туре тэргүүтэй Гвинейн засгийн газрын төлөөлөгчид манай улсад айлчилсан явдал монгол-гвинейн ард түмний харилцаанд төдийгүй БНМАУ, Африкийн орнуудын найрамдалт харилцааны шинэ хуудсыг нээсэн юм. БНМАУ, БНГУ-ын хамтарсан албан мэдээнд олон улсын харилцааны гол гол асуудлыг үнэлж дүгнэх талаар нэгдмэл үзэл бодолтой байгаагаа санал нэгтэй мэдэгджээ.⁹

1964 оны арван нэгдүгээр сард Бүгд Найрамдах Мали улсын засгийн газрын төлөөлөгчид манай улсад төрийн айлчлалт хийсэн юм.

1978 оны тавдугаар сард БНМАУ-ын засгийн газрын урилгаар Мозамбикийн ФРЕЛИМО намын дарга, Бүгд Найрамдах Мозамбик Ард Улсын ерөнхийлөгч Самора Мойзес Майел тэргүүтэй Мозамбикийн нам, засгийн төлөөлөгчид манай оронд албан ёсны найрсаг айлчлалт хийлээ.

Бүгд Найрамдах Мозамбик Ард Улс эрх чөлөөг эрхэмлэгч бүх хүчний чин хүндэтгэлийг хүлээж, Африк тивийн орнуудын дунд ихээхэн нэр хүндтэй бөгөөд олон улсын империализм, арьсны үзэлтнүүдийн түрэмгий халдлага, хорт явууллагад шийдвэртэй няцаалт өгч, өөрийн орны тусгаар тогтнол нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон тус тивд энх тайвныг сахин хамгаалахын төлөө тууштай зогсож байдаг юм. Энх тайван, бүх нийтийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай найрамдал, хамтын ажиллагаагаа цаашид батжуулах болон империализм, колоничлол, арьсны үзлийн эсрэг чиглэсэн Бүгд Найрамдах Мозамбик Ард Улсын гадаад бодлогыг БНМАУ-ын засгийн газар, Монголын ард түмэн өндөр үнэлдэг билээ. Монголын ард түмэн ФРЕЛИМО нам болон Мозамбикийн баатарлаг ард түмний үндэснийхээ эрх чөлөөний төлөө тэмцэхэд нь тууштай дэмжиж байлаа. Мозамби-

8 МАХН-ын XVII их хурал. УБ., 1976. 389-390-р тал.

9 БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, I боть, УБ., 1964. 246-248-р тал.

кийн нам, төрийн удирдагч Самора М. Машел тэргүүтэй Мозамбикийн нам, засгийн төлөөлөгчдийн манай оронд хийсэн найрсаг айлчлал нь МАХН, ФРЕЛИМО нам, манай хоёр орон, ард түмний найрамдалт хамтын ажиллагааг пролетарийн интернационализмын үндсэн дээр бэхжүүлэхэд том хувь нэмэр боллоо.

1967 оны нэг, хоёрдугаар сард БНМАУ-ын төлөөлөгчид Танзани, Этиопи, Гвиней, Алжир, Конго зэрэг улсад айлчилсан бөгөөд хэлэлцээний явцад Танзани, Этиопи улсуудтай дипломат харилцаа тогтоохоор хэлэлцэн тогтжээ. Мөн 1968 онд Монголын парламентын төлөөлөгчид Конго, Алжир, Мали, Гвиней зэрэг улсуудад айлчилсан бөгөөд тэдгээр орнуудын нам, төрийн удирдагчидтай уулзаж, орчин үеийн олон улсын чухал асуудал болон хоёр талын харилцан сонирхож байгаа асуудлуудаар харилцан саналаа солилцсон байна.

Бүгд Найрамдах Мозамбик улсын Гадаад явдлын яамны урилгаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын яамны төлөөлөгчид Мозамбик улсад 1977 оны тавдугаар сард албан ёсны айлчлал хийв. Монгол-Мозамбикийн харилцааны хөгжил, түүнчлэн олон улсын зарим асуудал, тухайлбал, Өмнөд Африк дахь колоничлол, арьсны үзэл, апартейдын асуудлаар хоёр орны Гадаад явдлын яамны төлөөлөгчид харилцан саналаа солилцов. Монголын төлөөлөгчид Мозамбикийн нийслэл Мапуту хотноо болсон Зимбабве, Намибийн ард түмнийг дэмжих олон улсын бага хуралд оролцож Зимбабве болон Намибийн газар нутгийг Өмнөд Африкийн арьсны үзэлтнүүд хууль бусаар эзэгнэж байгааг эсэргүүцсэн ард түмний тэмцэлтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. БНМАУ-ын Гадаад явдлын яамны төлөөлөгчид 1978 оны тавдугаар сард Бүгд Найрамдах Конго Ард Улсад албан ёсны найрсаг айлчлалт хийсэн байна. Айлчлалын үед хоёр тал БНМАУ, БНКАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны харилцааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх зориг хүслээ илэрхийлж, Африкийн улс түмний болон дэлхий дахины дэвшилт хүчний үйл ажиллагааны нэгдэл нягтралыг улам бэхжүүлэх нь чухал байгааг онцлон тэмдэглэв.¹⁰

Бүгд Найрамдах Монгол Ард Улс болон Африкийн орнуудын удирдах зүтгэлтнүүдийн найрсаг айлчлалтууд нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас шинэ тулгар хөгжиж байгаа Африкийн орнуудтай тогтоосон найрамдалт харилцаанд болон колоничлол, шинэ колоничлол, арьсны үзэлт дэглэмүүдийн эсрэг тэмцэж байгаа Африкийн ард түмэнтэй эв санаагаа нэгтгэх үйлсэд чухал хувь нэмэр оруулж байгаа юм. Манай улс Африкийн шинэ тулгар орнуудыг олон улсын тавцанд ийнхүү дэмжиж байгаагаас гадна соёлын харилцааны олон талын уламжлалтай билээ.

Дэлхийн социалист систем үүссэнээр үндэстний соёлын харилцан үйлчилж, бие биеэ баяжуулах зүй тогтоол улам өргөн баазтай болов. Социалист орнууд болон шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын соёлын ойртох үйл явц нарийн төвөгтэй, зөрчилтэй ч гэсэн эдийн засаг, улс төрийн нэгдмэл системийн үндсэн дээр олон талт интернационалч нэгдмэл соёлыг буй болгож болох юм.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Африкийн орнуудтай тогтоосон соёлын харилцаа нь монгол-африкийн ард түмний найрамдалт харилцаа улам батжин бэхжихэд чухал нөлөө үзүүлж байна. Одоо манай, улс Гвиней, Мали, Алжир, Конго, Мавритани зэрэг орнуудтай соёлын хэлэлцээр байгуулж, соёлын талаар хамтран ажиллаж байна.

10 «Үнэн», 1978. Ү. 19.

11 БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, 1 боть. УБ, 1964

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Гвиней Улсын хооронд соёлын хамтын ажиллагааны таван жилийн хугацаатай хэлэлцээр байгуулсан нь монгол-африкийн ард түмний соёлын харилцааны эхлэл болсон билээ. Соёлын хэлэлцээрийн үед БНГУ-ын ерөнхийлөгч Секу Туре хэлсэн үгэндээ: «...Энэ хэлэлцээрийн ёсоор тус хоёр орон хоорондоо соёлын төлөөлөгчдийг харилцан солилцоход өргөн бололцоо нээгдэж байна. Энэ бол Бандунгийн зарчим хэрэг дээрээ биелж байгааг харуулж байна»¹² гэж тэмдэглэжээ.

БНМАУ, Африкийн орнуудын соёлын харилцаа нь бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, бүрэн эрхт байдлыг хүндэтгэх, нөхөрсөг харилцааны үндсэн дээр соёл гэгээрэл, шинжлэх ухаан, урлаг, хүн эмнэлэг, биеийн тамирын салбаруудад хөгжиж байна. Тухайлбал, 1967 оны сүүлчээр Монголын урлагийн хэсэг Гвиней, Алжир, Египет зэрэг орнуудад амжилттай тоглосон бөгөөд Монголын үндэсний ба орчин үеийн соёл урлагтай Африкийн олон мянган үзэгчид танилцсан нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Африкийн орнуудтай тогтоосон соёлын харилцаа өргөжин бэхжиж ирсэний нэг жишээ юм. Мөн үндэсний баяраа харилцан тэмдэглэж, гэрэл зургийн үзэсгэлэн, баримтат кино, хэвлэл радиогийн болон соёлын бусад материал харилцан солилцож ирлээ.

Ийнхүү Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцаанд Африкийн орнуудын эзлэх жин улам бүр өсөн нэмэгдсээр байгаа билээ. МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга н. Ю.Цэдэнбал МАХН-ын XVII их хуралд тавьсан тайлан илтгэлдээ: «Манай нам, төрийн гадаад бодлогын үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь улс түмний эрх чөлөөний хөдөлгөөнийг тууштай дэмжиж Ази, Африк, Латин Америкийн орнуудтай найрамдалт харилцаагаа хөгжүүлэх явдал мөн»¹³ гэж тэмдэглэжээ. МАХН-ын гадаад бодлого дэлхийн социализмын байр суурь, хүч чадлыг зузаатган бэхжүүлэх, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний амжилтыг бататгах, Каригалист орнуудын ажилчин ангийн тэмцэлд таатай нөхцөл бүрдүүлэх үйлсэд чухал хүчин зүйл болсоор байна.

БНМАУ-ын Засгийн газар, Монголын ард түмэн, улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар тогтнолынхоо төлөө, шинэ колоничлол, арьсны үзэл, апартеид бодлогоос бүрмөсөн чөлөөлөгдөхийн төлөө тэмцэж байгаа Африкийн ард түмний тэмцлийг бүрэн дэмжиж, улс төр, эдийн засгийн тусгаар тогтнол, үндэсний бүрэн эрхт байдал, нийгмийн дэвшил, энх тайвны төлөө тэмцэж буй тус тивийн улс түмэн, хөдөлмөрчдийн тэмцэлтэй эв санааны нэгдэлтэй байна.

БНМАУ болон Африкийн шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа улам батжин бэхжих нь дамжиггүй юм.

12 «Үнэн», 1960. IX. 11. 95—96-р тал.

13 Монгол Ардын Хувьсгалт Намын XVII их хурал, УБ, 1976, 27-р тал,

СПРАВЕДЛИВАЯ БОРЬБА НАРОДОВ
АФРИКИ И ПОЛИТИКА МНР

Резюме

Статья посвящена анализу современной борьбы народов Африки и политике поддержки этой борьбы МНР, а также взаимоотношениям МНР со странами Африки.

Антиколониальная, антиимпериалистическая революция в Африке важная составная часть мирового революционного прогресса. Она разворачивается в условиях, когда социализм стал решающим фактором исторического развития; ее успехи возможны только при неразрывной связи с интернациональной поддержкой стран социалистического содружества.

Империалисты всеми средствами пытаются удерживать африканские страны в своей орбите, воспрепятствовать расширению их связей с социалистическими государствами и мировым революционным движением. Цель империалистических монополий- навязать Африке реколонизацию и новую форму эксплуатации и угнетения.

Африканским патриотам еще предстоит упорная борьба за полное освобождение континента. Неуклонно ширится борьба за изгнание колонизаторов с их последних владений на африканской земле. В странах, до бившихся политической независимости, национально-освободительная революция в новый этап-этап борьбы за упрочение политической и достижение экономической независимости.

Революционный опыт учит, что в современных условиях победоносно завершить национально-освободительную революцию на континенте-значит вывести африканские страны на путь социалистической ориентации.

При отсутствии широкого пролетарского движения революционно-демократические партии играют в настоящее время руководящую роль в странах социалистической ориентации.

В статье занимает большое место анализ взаимоотношений МНР и молодых африканских стран. Особенно тесное сотрудничество МНР осуществляет теми странами, которые проводят линию последовательно революционных социально-экономических преобразований, а на международной арене активно борются против сил империализма, неоколониализма и расизма.

В заключение автор пишет о значении взаимоотношений МНР и развивающихся стран Африки для совместной борьбы социалистических и развивающихся государств за мир и международное сотрудничество, за свободу и независимость народов. Автор также отмечает, что молодые развивающиеся страны могут добиться подлинной политической и экономической независимости, успешно противостоять диктату империализма только при тесном и всестороннем сотрудничестве социалистическими странами.

По мнению автора, всевозрастающее значение приобретает опыт социально-экономического развития МНР для молодых развивающихся стран Африки.